



ҮАГ-ын төлөвлөөгний дагуу Хэнтий аймгийн Аудитын газрын
2015 онд хийсэн **НИЙЦЛИЙН АУДИТ**

**ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХДЭЭ
ЦАХИМ САНД МЭДЭЭЛЛИЙГ ХУГАЦААНД НЬ
ТОГТМОЛ, БҮРЭН БАЙРШУУЛЖ ХЭВШЭЭГҮЙ БАЙНА**

Зохион байгуулалтын нэгж **НИЙЦЛИЙН АУДИТЫН БАГ**

Аудитын код: **ҮАГ-НАГ/2015/07-НА-ХЭ**

Аудитын нэр: **Шилэн дансны тухай хуулийн
хэрэгжилт**

Чингис хот

2015 он

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

[illegible]

Тайлан бэлтгэсэн ҮАГ-ын харъяа Хэнтий аймгийн Аудитын газар	АГУУЛГА	
	Ерөнхий зүйл	
Хэнтий аймгийн Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Ц.Энхтүвшин	Аудитын нэр,код	2
	Аудит хийсэн үндэслэл, хугацаа	2
Аудитын менежер: Б.Наранцэцэг	Аудитын зорилт	2
	Аудитын хамарсан хүрээ	2
Ахлах аудитор: Н.Туяа	Үндсэн мэдээлэл	2
	Нэг. Хуулийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж байгаа бол, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллага хуулийн хэрэгжилтэд хамрагдаагүй байна.	
Шинжээч: Д.Эрдэнэбилэг Б.Мөнгөнцэцэг	1.1 Хуулийн 3.1.1-д заасан байгууллагууд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж байна.	2
	1.2 Хуулийн 3.1.2-д заасан байгууллагууд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж байна.	4
2015 оны 12 дугаар сар	1.3 Хуулийн 3.1.4-д заасан байгууллагууд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байна.	5
	1.4 Хуулийн 3.1.5-д заасан байгууллага Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хамрагдаагүй байна.	
Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал аймгийн Аудитын газрын 7056-2147, 98332147 тоот утас, khentii@audit.gov.mn, 70562112 факсаар харилцана уу.	Хоёр. Шилэн дансны мэдээллийг нэгдсэн систем болон байгууллагын мэдээллийн самбарт мэдээлэл байршуулах үүрэг бүхий зарим албан тушаалтнууд мэдээллээ бүрэн оруулаагүй байна.	6
	2.1. Хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6.1-д заасан мэдээллийг тогтмол бүрэн мэдээлээгүй байна	6
Хаяг: Хэнтий аймаг Чингис хот АЗДТГ-ын байр. 325 тоот өрөө	2.2. Хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6.4-т заасан мэдээллийг 7 хоногийн дотор байршуулахаас бүрэн байршуулаагүй байна.	11
	2.3. Хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагууд 6.9-д заасан мэдээллийг журмын дагуу мэдээлээгүй байна.	14
	Гурав. Хуулийн хэрэгжилтэд ТЕЗахирагч, Санхүүгийн дотоод аудитын алба хяналт тавьж ажиллаж байна.	
	3.1 Аймгийн ИТХ болон сумын ИТХ-ын байгууллагууд хуулийн хэрэгжилтэд хяналт хийсэн талаар мэдээ баримт байхгүй байна.	15
	3.2 ТЕЗ-ийн зүгээс хуулийн хэрэгжилтэд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаж байгаа боловч зөрчил дутагдал арилаагүй байна.	15
	3.3 Шилэн дансны нэгдсэн цахим хуудас, журмыг боловсронгуй болгох шаардлагатай байна.	16
	Холбогдох байгууллагын санал	
	Дөрөв. Хавсралтууд	
	Хэнтий аймгийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн судалгаа	

Нэг. Ерөнхий зүйл

Аудитын нэр: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Аудитын код: УАГ-НАГ/ 2015 /07- НА-ХЭ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.3, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтыг үндэслэн аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүнг холбогдох бөагууллага, албан тушаалтанд танилцуулан олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдэв. Дээрх зорилтыг хангахын тулд дараах зорилтыг хэрэгжүүлэв.

Үүнд:

- Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд бүрэн хамрагдаж байгаа эсэх,
- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д заасан байгууллагууд 6 дугаар зүйлд заасан мэдээллийг мэдээлж байгаа эсэх,
- Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т заасан этгээд хяналтыг хэрэгжүүлж байгаа эсэх,
- Иргэдийн хяналт ба өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд тус тус аудит хийв.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад “Шилэн дансны тухай хууль”-ийн 3 дугаар зүйлийн 3.1.1- 3.1.5-д заасан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газар, албан тушаалтнуудыг хамруулсан ба Хэрлэн, Цэнхэрмандал, Жаргалтхаан, Дэлгэрхаан, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр, Дадал, Норовлин, Батноров, Баян-Овоо, Галшар, Өмнөдэлгэр буюу нийт сумдын 59 хувийг хамруулан төсвийн байгууллагуудын шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг газар дээр нь үзэж шалгасан.

Үндсэн мэдээлэл

Улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх зорилго бүхий “Шилэн дансны тухай” хууль 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.

Монгол Улсын Засгийн газраас дээрх хуулийг олон нийтэд таниулан сурталчлах, мэдээлэл арга зүйгээр хангах чиглэлээрх сургалтыг яам, агентлаг, аймаг, нийслэл, дүүргийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит компани, төрийн бус байгууллагын ажилтнуудад хийжээ.

“Шилэн дансны тухай” хуулийн зарчим нь мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн, ойлгомжтой, ач холбогдолтой, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх явдалд үндэслэгдсэн байна.

Үндэсний аудитын газраас 2015 оны 5 дугаар сард “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитад 5804 байгууллага хамрагдсан ба аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Монгол Улсын Ерөнхий сайдад Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Сангийн яамны “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулах чиг үүрэгт анхаарлаа хандуулж, нэгдсэн арга зүйгээр хангах, хяналтын асуудлыг шийдвэрлэх, аймаг, сумдын төсвийн болон төрийн байгууллагын ажилтнууд, иргэдэд “Шилэн дансны тухай” хуулийг сурталчлах ажлыг эрчимжүүлэх, хөдөө орон нутагт “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор техник хэрэгслийн хангамжийг сайжруулах, интернет сүлжээ байгуулах, байнгын цахилгааны эх үүсвэртэй болгох арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн байна.

2015 оны 5 сард “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийн судалгааг ТЕЗ-ийн хүрээнд 1, ТТЗ-ийн хүрээнд 22, ТШЗ-ийн хүрээнд 215, ТБОНӨ хуулийн этгээдийн 9 байгууллага буюу нийт 247 байгууллагад байршуулбал зохих мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудас, байгууллагын цахим хуудсанд хэрхэн байршуулсаныг хянан үзэж гаргажээ.

Энэ судалгаанд хамрагдсан 247 байгууллагаас нэгдсэн цахим хуудсанд 15.8 хувь буюу 38 байгууллага мэдээллийг байршуулаагүй, “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай” журмын 4.1, 7.2-ын заалтыг зөрчсөн байсан. Үүнд: Дэлгэрхаан, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Баянмөнх, Баян-Овоо, Баянмөнх, Баянхутаг, Норовлин сумын ТЕЗ болон Гурван баян, Өлзийт, ХБУ-н тосгоны Захирагч, ЗХ-ний 232-р анги, Улсын Нөөцийн Хэнтий салбар, Онон голын сав газар, Баянхутаг сумын ЗДТГ, БЗД, Баянмөнх сумын ИТХ, ЗДТГ, БЗД, ЕБС, Цэцэрлэг, ЭМТ, Дархан сумын БЗД, ХБУ тосгоны Цэцэрлэг, ЭМТ, Цэнхэрмандал сумын ИТХ, Баян-Овоо сумын ИТХ, Гурван баян тосгоны ЗАА, ЕБС, Цэцэрлэг, ЭМТ, Соёлын төв, Норовлин сумын БЗД, Тахилгат тосгоны ЗАА, Аймгийн Номын сан, Хэрлэн сумын “Ач манал”, “Оюуны шим”, “Хэрлэн дом” өрхийн эмнэлгийн зэрэг төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн шууд захирагч нар шилэн дансны хууль, журмыг хэрэгжүүлээгүй байсан байна.

Хэнтий аймгийн хэмжээнд “Шилэн дансны тухай” хуулийн дагуу шилэн дансны мэдээллээ байршуулаагүй байсан 3 байгууллагад мэдээллээ байршуулах албан шаардлага, сумдын Засаг дарга нарт мэдээллийг бүрэн байршуулах албан бичиг хүргүүлжээ.

2015 оны 10 сарын байдлаар Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 289 байгууллага, этгээдийн цэс нээснийг авч үзэхэд: Аймгийн ТЕЗ-ийн 1, сумдын ТЕЗ-ийн төрийн сангийн 22, улсын төсвөөс санхүүжилт авдаг төсөвт байгууллагын 141, орон нутгийн төсвөөс санхүүжилт авдаг орон нутгийн төсөвт байгууллагын 47, ОНӨҮГазар, хуулийн этгээдийн 17, **ТӨХК-ийн 2** цэс тус тус нээснээс гадна гүйлгээ гараагүй, хуулийн этгээд биш, цэс нээх шаардлагагүй Багийн засаг даргын 18, Орон нутгийн хөгжлийн сангийн 4, Орлогын дансны 2, орон нутгийн сангуудын 5, сонгуулийн хорооны 2, хувийн сургууль, цэцэрлэгийн 2 цэсүүд нээгдсэн боловч огт мэдээлэл оруулаагүй, хагас дутуу мэдээлэл оруулсан ба мөн давхардсан, андуурсан, алдаатай 26 цэс нээсэн байна. /Хавсралт №1/

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд нийцлийн аудитын олон улсын стандарт 4200 болон төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглахын зэрэгцээ "Шилэн дансны тухай" хуулийн 3 дугаар зүйл, 8 дугаар зүйлд заасан байгууллага, аж ахуйн нэгж нэгдсэн болон өөрийн цахим хуудас, мэдээллийн самбарт байрлуулсан мэдээллийг харилцах дансны хуулгын дүн, анхан шатны баримт, журналтай тулгах, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитад дараахь хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Засгийн газрын 2014 оны 1- дугаар сарын 15-ны 384 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

10. Аудит хийсэн хугацаа:

Аудитыг 2015 оны 11 дүгээр сарын 02-ноос 12 дугаар сарын 15-ны хооронд хийж гүйцэтгэлээ.

11. Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн:

Аудитыг аймгийн аудитын газрын аудитын менежер Б.Наранцэцэг хянан удирдаж, ахлах аудитор Н.Туяа багийг ахлан, ахлах аудитор Х.Еркегүл, шинжээч Д.Эрдэнэбилэг, Б.Мөнгөнцэцэг, аудитор Ү.Төгсжаргал, Ц.Нарангэрэл, Ц.Хатанболд нар гүйцэтгэв.


Нэгдүгээр
бүлэг

- Хуулийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд "Шилэн дансны тухай" хуулийн хэрэгжилтэд бүрэн хамрагдаж, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллага хуулийн хэрэгжилтэд хамрагдаагүй байна.

1.1. “Шилэн дансны тухай” хуулийн 3.1.1-д заагдсан байгууллагууд бүрэн хамрагдаж байна.

“Шилэн дансны тухай” хуулийн 3.1.1-д заасны дагуу аймаг, сумдын ТЕЗ буюу төрийн сан 23, улсын төсвөөс санхүүждэг 141 төрийн өмчит хуулийн этгээд, орон нутгийн төсвөөс санхүүждэг 47 байгууллага, Орон нутгийн өмчит 17 хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газар 2, нийт **230** хуулийн этгээд бүрэн хамрагдсан байна.

ШИЛЭН ДАНСАНД МЭДЭЭЛЭЛ ОРУУЛСАН ААН-ҮҮД



1.2. Шилэн дансны тухай хуулийн 3.1.2-д заагдсан байгууллагууд бүрэн хамрагдаж байна.

“Шилэн дансны тухай” хуулийн 3.1.2-д заасны дагуу Харгуй ТӨХК, Нисэх буудал ТӨААТҮГ нь шилэн дансны цахим хуудсанд мэдээллээ байршуулж бүрэн хамрагджээ.

1.3. Шилэн дансны тухай хуулийн 3.1.3-д заагдсан байгууллагууд аймагт үйл ажиллагаа явуулдаггүй байна.

“Шилэн дансны тухай” хуулийн 3.1.3-д заасны дагуу хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани аймгийн хэмжээнд байгуулагдаагүй байна.

1.4. Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-д заагдсан байгууллагууд хуулийг хэрэгжүүлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.4-д хамаарах Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа 92 ААН, байгууллага, төрийн бус байгууллага 1, бүлэг хоршоо 11 байна.

Гэвч эдгээр байгууллагуудад шилэн дансанд мэдээлэл оруулах талаарх ойлголт байхгүйгээс мэдээллээ байршуулаагүй байна.

1.5. Шилэн дансны тухай хуулийн 3.1.5-д заагдсан байгууллагууд бүрэн хамрагдаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 3.1.5-д заасны дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч байгууллагууд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллээ байршуулахаас хүүхдийн “Хэрлэн” зуслангийн үйл ажиллагааг менежментийн гэрээгээр гүйцэтгэгч “Хөвчийн жонон” ХХК зуслангийн үйл ажиллагааныхаа талаар, төсвөөс санхүүжилт авдаг “Чөлөөт Ахмадын холбоо” үйл ажиллагааныхаа талаар мэдээлэл байршуулах цэс Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд үүсээгүй байна.

Хоёрдугаар
бүлэг


- Шилэн дансны мэдээллийг нэгдсэн систем болон байгууллагын мэдээллийн самбарт мэдээлэл байршуулах үүрэг бүхий зарим албан тушаалтнууд мэдээллээ бүрэн оруулаагүй байна.

2.1. Хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6.1-д заасан мэдээллийг тогтмол бүрэн мэдээлээгүй байна.

Аймгийн Аудитын газрын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн судалгаанаас хуулийн 3.1.1-т заасан төрийн болон орон нутгийн өмчит этгээд, 3.1.2-т заасан төрийн өмчит үйлдвэрийн газар нь хуулийн 6.1-д заагдсан мэдээллийг байршуулсан эсэхийг авч үзэхэд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд:

6.1.1. Тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор байршуулахаас тухайн жилийн төсвийг байршуулах 224 байгууллагаас 201 байгууллага буюу 89.7 хувь нь төсвийн гүйцэтгэлийн хэсэгт шивж байршуулсан ба батлагдсан төсвийн шийдвэр, задаргааг файлаар хавсаргаагүй байна. ОНХС-ийн төлөвлөгөөг 23 ТЕЗ байршуулахаас 26.1 хувь буюу аймгийн ТЕЗ, Дархан, Дадал, Баян-Адрага, Батширээт, Бор-Өндөр сумын ТЕЗ байршуулсан байна. **Дэлгэрхаан, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Баянмөнх, Галшар, Өмнөдэлгэр, Хэрлэн, Биндэр, Баян-Овоо, Норовлин, Батноров, Мөрөн, Баянхутаг сум, Бэрх, Хэрлэнбаян-Улаан, Өлзийт, Гурванбаян тосгоны ОНХС-ийн төлөвлөгөөг байршуулаагүй байна.** Худалдан авалтын төлөвлөгөөг 65 байгууллага байршуулахаас 8 байгууллага буюу 12.3 хувь нь байршуулж, **87,7 хувь нь байршуулаагүй байна.**



Нэгдсэн цахим хуудсанд Төсвийн эрх захирагчийн гүйцэтгэлийг хэмжих тоон болон чанарын үзүүлэлт хүрсэн үр дүн, өмч хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэрийг тавьсан байгууллага байхгүй байна.


6.1.2. хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор байршуулах 227 байгууллагаас 216 буюу 95.1 хувь нь сар бүрийн төсвийн гүйцэтгэлийг мэдээлж, **4.9 хувь нь мэдээлээгүй байна**. Өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг аймгийн ТЭЗ мэдээлснийг эс тооцвол бусад байгууллага огт байршуулаагүй байна.

6.1.3. дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор мэдээлэх 224 байгууллагаас 45 байгууллага буюу 20 хувь нь нэгдсэн цахим хуудас болон мэдээллийн самбараар мэдээлж үлдэх **80 хувь мэдээлээгүй байв**.

6.1.4. жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор мэдээлэх 227 байгууллагаас жилийн эцсийн санхүүгийн тайланг 70 байгууллага буюу 30.8 хувь нь, хагас жилийн санхүүгийн тайланг 63 байгууллага буюу 27.7 хувь нь мэдээлж, **72.3 хувь мэдээлээгүй байна**.

6.1.5. төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор 86 байгууллага, ТЭЗ мэдээлэхээс аудитын дүгнэлтийг 20 байгууллага буюу 23.2 хувь нь мэдээлж **76.8 хувь нь мэдээлээгүй**, аудитын мөрөөр авсан арга хэмжээг 32 байгууллага мэдээлсэн байна.

6.1.6. төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр мэдээлэх 203 байгууллагаас 84 байгууллага буюу 41,4 хувь нь мэдээлж, **58.6 хувь нь мэдээлээгүй байна.**



Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд сумын ТЕЗ-ийн төсөв буюу орон нутгийн ерөнхий орлого, ИТХ, ЗДТГ, ЕБС, Цэцэрлэг, ЭМТөв, Соёлын төв зэрэг байгууллага нь жилийн төсөв, төсвийн гүйцэтгэл, 5 сая төгрөгөөс дээш гүйлгээ, ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн мэдээллийг ихэвчлэн байршуулсан байна.

Мөн хандив, тусламж, түүний зарцуулалтыг Өмнөдэлгэр сумын ЗДТГ, аймгийн ЗДТГ, Хөдөлмөрийн хэлтэс, 5-р Цэцэрлэг зэрэг байгууллагууд мэдээлсэн байна.

Орон нутгийн сангуудын гүйлгээ, мэдээллийг сумын ТЕЗ нар шилэн дансны цахим мэдээллийн санд байршуулаагүй байна.

Нэгдсэн цахим хуудсанд цэс нээгдсэн боловч “Орон нутгийн хэвлэл мэдээллийн алба”, “Цэнхэрмандал ой анги”, “Биндэр нийтлэг үйлчилгээ” ОНӨГазрууд болон үйл ажиллагаагаа явуулаагүй “Өндөрхаан сүү” ОНӨААТҮГ, “Баянмөнх сум тохижилт” зэрэг ОНӨААТГазрууд мэдээлэл огт оруулаагүй байна.

	Хамрагдах байгууллага, этгээд	мэдээлэл байршуулвал зохих этгээдийн тоо	нэгдсэн цахим хуудсанд цэс нээгдсэн тоо	мэдээллээ байршуулсан этгээдийн тоо
1	Улсын төсвийн байгууллага	141	141	141
2	Орон нутгийн төсвийн байгууллага	47	47	47
3	ТЕЗ-ийн СНТайлан	23	23	23
4	ОНӨҮГ	17	17	6
5	ТӨХК	2	2	2
7	Гэрээгээр үүрэг гүйцэтгэгч	2	0	0
	Нийт дүн	232	230	219

Байгууллагын цахим хуудсанд:

Хэнтий аймгийн ЗДТГ “Иргэдийн цахим мэдээллийн систем”-ийг энэ оны 10 дугаар сараас аймгийн ЗДТГ-ын байранд ажиллуулж эхэлсэн нь Санхүүтэй холбоотой

мэдээллийг нэгдсэн портал сайт ба мэдээллийн самбараас танилцах, аймгийн төвийн 30 шахам төсвийн байгууллагын талаарх мэдээллийг нэг цэгээс харах боломж бүрдэж байгаагаараа ач холбогдолтой болжээ.



“Иргэдийн цахим мэдээллийн систем”-д аймгийн ТЕЗ, СТСХ, ХААА нь:

“Санхүүгийн ил тод байдал” хэсэгт аймгийн төсөв, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, хөрөнгө оруулалт, төсвийн орлого, аймгийн төсвийн байгууллагуудын урсгал зардлын өдөр тутмын гүйлгээний жагсаалт, 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээ, аудитын дүгнэлт, шийдвэрийн жагсаалт гэсэн цонх нээж холбогдох мэдээллүүдийг байршуулж ил тод байдлыг хангаж байна.

“Худалдан авах ажиллагаа” хэсэгт бараа ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө, зарлагдсан тендер, тендерийн нээлт, үр дүн гэсэн цонх нээж холбогдох мэдээллийг байршуулсан байна.

Мөн аймгийн ЗДТГ- khentii.gov.mn сайт ажиллуулан аймгийн ТЕЗ, СТСХ, ХААА нь:

“нээлттэй төр” хэсэгт төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, үр дүнгийн талаарх мэдээлэл, үйлчүүлэгчээс авч буй үнэ тариф, төлбөр хураамжийн талаарх мэдээлэл, гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, түүний талаарх мэдээлэл, бусад мэдээллүүдийг, “тендер” хэсэгт тендерийн урилга, концесстой холбоотой мэдээллийг байршуулж ажиллаж байна.


“Шилэн данс” хэсэгт төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл, ОНХО-аар хийгдсэн 2014 оны ажил болон 2015 онд хийгдсэн 16 ажлын сар бүрийн мэдээ, төлөвлөгөө, гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээ, ОНХС-ийн 2014, 2015 оны сар бүрийн мэдээ, төлөвлөгөө, гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээ, СТСХ-ийн 7 хоног бүрийн ажлын мэдээ, ОНХС-ийн нийцлийн аудитын тайлан, мөн аймгийн Засаг дарга, ОНХС, Захиалагчийн хяналт, Малыг эрсдлээс хамгаалах сан, Замын сангийн дансдын 5 сая төгрөгөөс дээш гүйлгээ, Хэнтий аймгийн Төвийн төрийн сангийн зарлагын гүйлгээний жагсаалтыг өдөр бүрээр, аймгийн Засаг даргын 3-6 сарын 17 шийдвэрийг мэдээлж төсвийн ил тод байдлыг хангаж ажиллаж байна.

Байгууллагын мэдээллийн самбарт:

Хэрлэн, Цэнхэрмандал, Жаргалтхаан, Дэлгэрхаан, Баянмөнх, Дархан, Бор-Өндөр, Дадал, Норовлин, Батноров, Баян-Овоо, Галшар, Өмнөдэлгэр сумдын ЗДТГ-ын мэдээллийн самбарт жилийн төсөв, төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, аудитлагдсан санхүүгийн тайлан, сумын төсвийн орлогын гүйцэтгэлийн мэдээ, ОНХС-ийн 2015 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт хөтөлбөрийн жагсаалт, бараа ажил үйлчилгээ худалдан авах ажлын гүйцэтгэл, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн тайлан, тендерийн зар, ЖДБДС, СХС-аас төсөл хэрэгжүүлэгч иргэдийн жагсаалтыг байршуулжээ.

Харин Дэлгэрхаан, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Бор-Өндөр, Баянмөнх, Дархан, Дадал, Баян-Адрага, Норовлин, Өмнөдэлгэр, Батноров, Галшар, Хэрлэн сумын ИТХ, ЕБС, Цэцэрлэг, ЭМТ, Соёлын төвүүд мэдээллийн самбартаа төсвийн гүйцэтгэлийн мэдээ, батлагдсан амралтын тушаал, худалдан авсан хөрөнгийн жагсаалт, хяналт шалгалтын тайлан зэрэг мэдээллийг байршуулсан байна.

БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЛИЙН САМБАРЫН ЗУРГИЙГ ҮЗҮҮЛВЭЛ:



Дэлгэрхаан сумын ЭМТ-ийн мэдээллийн самбар



Цэнхэрмандал сумын ЗДТГ, Жаргалтхаан сумын ЕБС-ийн мэдээллийн самбар


2.2. Хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллагууд 6.4-т заасан мэдээллийг 7 хоногийн дотор байршуулахаас бүрэн байршуулаагүй байна.

Хуулийн 3.1.1-т заасан төрийн болон орон нутгийн өмчит этгээд, 3.1.2-т заасан төрийн өмчит үйлдвэрийн газар нь хуулийн 6.4-д заагдсан дараах мэдээллүүдийг шилэн дансны нэгдсэн цахим хуудас, мэдээллийн самбар, байгууллагын цахим хуудаст мэдээлсэн эсэхэд хийсэн судалгаанаас үзэхэд:

- тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг 7 хоногийн дотор мэдээлэхээс 94 байгууллагын 84 байгууллага төсвийн гүйцэтгэлийг мэдээлэхдээ жилийн төсвийг шивж оруулсан бол **10 байгууллага төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг**

мэдээлээгүй байна. Тухайлбал: УЦУОШ, Цагдаагийн газар, аймгийн болон Бор-Өндөрийн сум дундын Прокурорын газар, Жаргалтхаан, Цэнхэрмандал сумын төсөвт байгууллагууд.

- тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлтийг аймгийн Засаг даргын тамгын газар Архивын үйлчилгээний, Мэргэжлийн хяналтын газар, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв үнэ тарифын өөрчлөлтийг мэдээлж ажиллажээ.
- тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгааныг мэдээлэхээс 305 тендерт оролцогчийн 257 оролцогч буюу 84.3 хувийг, шалгарсан 192 оролцогчийн 176 буюу 91,7 хувийг, шалгараагүй 113 оролцогчийн мэдээллийг мэдээллийн самбарт мэдээлсэн байна.




- таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг зэрэг 231 худалдан авалтийг мэдээлэхээс 14.0 тэрбум төгрөгийн 219 худалдан авалтыг мэдээлж, **139,0 сая төгрөгийн 12 худалдан авалтыг мэдээлээгүй байна.**

5.0 сая.төг-с дээш дүнтэй тендер гүйцэтгэгчийг мэдээлсэн байдал



- цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг мэдээлэхээс зарлагын гүйлгээний 51.2 тэрбум төгрөгийн 463 гүйлгээг мэдээлж, **238.5 сая төгрөгийн 23 гүйлгээг мэдээлээгүй**, орлогын гүйлгээний 32.1 тэрбум төгрөгийн 272 гүйлгээг мэдээлж, **1.2 тэрбум төгрөгийн 63 гүйлгээг мэдээлээгүй** байна.

ОРЛОГО, ЗАРЛАГЫН ГҮЙЛГЭЭГ МЭДЭЭЛСЭН БАЙДАЛ



- худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүнг шалгалтын дүнг мэдээлвэл зохих 51 байгууллагаас 44 байгууллага мэдээлж, **Гурванбаян тосгоны ЭМТ, Соёлын төв, Батширээт сумын ЭМТ, Норовлин сумын ТЭЗ, Галшар сумын ИТХ, Батширээт ЗДТГ, Өмнөдэлгэр сумын ИТХ, Баянхутаг сумын ЗДТГ мэдээлээгүй** байна.
- байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийг мэдээлэхээс **аймгийн ИТХурал, Мэргэжлийн хяналтын газрууд орон тооны өөрчлөлтөө мэдээлээгүй** байна.

6.4.8. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийн мэдээллийг байршуулахаас

концесстой холбоотой аймгийн ИТХ-ын тогтоолыг иргэдийн цахим систем, khentii.gov.mn сайтад мэдээлсэн байна. Аймгийн ТЕЗ-ийн хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой тушаал, шийдвэрийн жагсаалтыг ил тод мэдээлснийг үзэхэд khentii.gov.mn сайтад 1-3 сарын 442,2 сая төгрөг зарцуулах тухай 110 захирамжийг байршуулж, бусад **захирамжийг байршуулаагүй** байна.

Дээрхи судалгааны дүнгээс үзэхэд байгууллагын, дарга нягтлан бодогч нарын шилэн дансны цахим хуудаст мэдээлэл байршуулах ойлголт мэдлэг болон ажлын хариуцлага сул байгаагаас шалтгаалан аймгийн хэмжээнд хуулийн дагуу мэдээлэх мэдээллүүдийг хуулийн хугацаанд, бүрэн мэдээлж байршуулаагүй байна. Тухайлбал Өрхийн Эрүүл мэндийн төвүүд 1 хүнд ноогдох зардлаар санхүүжиж, зөвхөн авсан санхүүжилтээ оруулж, өөр мэдээлэл оруулаагүй бөгөөд мэдээллээ хэрхэн шивэх нь тодорхойгүй байна.

2.3. Хуулийн 3.1.4, 3.1.5-д заасан байгууллагууд 6.9-д заасан мэдээллийг журмын дагуу мэдээлээгүй байна.

Хуулийн 3.1.4-т заасан улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, 3.1.5-д заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч нь хуулийн 6.9-д заагдсан-нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг байршуулахаар заасан боловч тухайн байгууллагын нэгдсэн цахим хуудас, байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт мэдээллээ байршуулах талаар ойлголт байхгүй, тогтолцоо, боломж нөхцөл бүрдээгүй учраас байршуулаагүй байна.

Харин төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч ТЕЗахирагч, төрийн сан, байгууллага нь хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалт, ажил үйлчилгээний төсөвт өртөг, олгосон санхүүжилтийг өөрийнхөө цахим хуудас, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш худалдан авалт, тендерийн мэдээлэл хэсэгт болон мэдээллийн самбараар мэдээлж ажиллаж байна.

Харин аймгийн ЗДТГ, төрийн сан нь ОНХС, ОНХО, УТХО, Замын сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлын мэдээллийг тогтмол “Иргэдийн цахим мэдээллийн систем”-д мөн khentii.gov.mn сайтад байршуулж ажилласан байна.

Гуравдугаар бүлэг

• **Хуулийн хэрэгжилтэд ТЕЗ, Санхүүгийн хяналт, аудитын алба хяналт тавьж ажиллаж байгаа боловч зөрчил дутагдал арилаагүй байна.**

3.1. Хуулийн 8.1-д заасан аймгийн ИТХ болон сумын ИТХ-ын байгууллагууд хуулийн хэрэгжилтэд хяналт хийсэн талаар мэдээ, баримт байхгүй байна.

Аймгийн ИТХ-аас 2014 онд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулж ажилласнаас өөр мэдээлэл байхгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 8.1-д “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн шилэн дансны үйл ажиллагаанд тавих хөндлөнгийн хяналтыг бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, иргэдийн Нийтийн Хурал, төрийн аудитын байгууллага хэрэгжүүлнэ.” гэж заасны дагуу аймгийн Аудитын газар хуулийн хэрэгжилтийг Дэлгэрхаан, Цэнхэрмандал, Жаргалтхаан, Бор-Өндөр, Дархан, Баянмөнх, Өмнөдэлгэр, Норовлин, Дадал, Баян-Овоо, Батноров, Галшар, Хэрлэн сумдыг хамруулан шалгахад дээрхи

заалтын хэрэгжилт хангалтгүй бөгөөд **ИТХ-аас хяналт хийсэн мэдээ баримт байхгүй** байна.

Иймд тухайн сумдын ИТХ-ын дарга нарт Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг, Засаг дарга, байгууллагын дарга, нягтлан бодогч нарт шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд нь бүрэн байршуулж байх талаар зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитаар нийт 1577.5 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй зөрчил илрүүлснээс ХХААГ, Баянхутаг сумын ЗДТГ, ЭМТ, ЕБС, Цэцэрлэг, Батширээт сумын Төрийн сан, Батширээт сумын тохижилт ОНӨҮГ-т мэдээллээ бүрэн байршуулж зөрчлийг арилгах 7 албан шаардлага хүргүүлээ.

3.2. Хуулийн 8.2-т заасан ТЕЗ-ийн зүгээс хуулийн хэрэгжилтэд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллаж байгаа зөрчил бүрэн арилаагүй байна.

Мөн энэ хуулийн 3.1.1-д заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлэхээр байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан журам, Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг удирдлага болгон хяналтыг хэрэгжүүлж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 11 дугаар сард хяналт шалгалт хийж ажиллажээ. Шалгалтын хугацаанд мэдээллээ байршуулах ажлыг тогтмолжуулах, тавигдах мэдээллийг бүрэн оруулах зэргээр хуулийн хэрэгжилтийг хангахад анхаарвал зохих асуудлаар зөвлөмж, зөвлөгөөг өгч ажиллаж байгаагийн зэрэгцээ Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг холбогдох маягтуудаар гарган улирал бүр Сангийн яаманд хүргүүлж ажилласан байна.

Хэдийгээр Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт тавьж ажилладаг боловч аудитад хамрагдсан байгууллага, этгээд нь мэдээллээ бүрэн байршуулаагүй зөрчил дутагдал арилаагүй байна.

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж шилэн дансанд мэдээлэл оруулах явцад аж ахуйн нэгж, байгууллагуудын нэрийг Улсын бүртгэлийн албанаас оноосон нэртэй тулгалт хийж баталгаажуулдаггүй, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэхэд хамрагдах ТЕЗ-ийн харьяа байгууллагыг аймагт тодорхой болгоогүй, батлагдсан төсөвтэй уялдуулж ЗДТГ-т харъяалагдах 19 багт байгууллагын цэс нээсэн, мэдээний нэр төрөл давхардалтай, байгууллагын дараалал цэгцгүй, үйл ажиллагаа явуулаагүй, ажиллах эсэх нь тодорхойгүй байгууллагыг тайланд хэрхэн хамруулахыг шийдвэрлээгүй, хуулийн заалт, журам, мэдээ гаргах үзүүлэлт, маягтаа хооронд нь уялдуулаагүй, мэдээлэл нь иргэдэд ойлгоход энгийн, хялбар биш зэрэг асуудлууд илэрсэн байна.

3.3. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байгууллагууд мэдээллээ бүрэн байршуулаагүй байгаа нь нэгдсэн цахим хуудсанд төсвийн төсөл, санхүүгийн тайлан,

аудитын дүгнэлт зэргийг оруулах цэс байхгүй, зарим мэдээллийг хаана хэрхэн байршуулах талаар нягтлан бодогч, санхүүгийн ажилтнууд бүрэн ойлголт байхгүй зэргээс шалтгаалж байна. **Дараах тодорхой бус, хүндрэлтэй асуудлууд гарч байна.**

- “Шилэн дансны тухай” хуулийн 3.1.1, 3.1.2-д төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд мэдээлэл байршуулна гэж заасан боловч аймаг, сумын нэгдсэн төсөв, ТЕЗ-ийн мэдээллийг мэдээлэх шаардлагатай тул Ерөнхий орлого гэсэн цэс үүсгэж мэдээлсэн байна.
- **Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байгууллагын нэмэлт дансны гүйлгээг байршуулдаггүй байна.**
- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тендерт оролцогчдын мэдээллийг оруулах боломжгүй, оролцогч аж ахуйн нэгжүүдийн нэрс сонгогдох жагсаалтад байхгүй байна.
- Нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл оруулсан сар өдөр харагдахгүй байна.
- Үйл ажиллагаа явуулаагүй, төсвөөс санхүүжилт аваагүй орон нутгийн өмчит байгууллагын мэдээллийг хэрхэн оруулах нь тодорхойгүй, цэс нээгээд орхисон байна.
- Нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг хаана оруулах нь тодорхойгүй, ойлгомжгүй, мэдээг давхардуулсан байна.
- Хуулийн заалт, журам, мэдээ байршуулах үзүүлэлт, маягт хоорондоо уялдаа муу байна.

Дөрөв. ДҮГНЭЛТ

1. Шилэн дансны тухай хуулийн дагуу хяналт тавих эрх бүхий байгууллага хяналт хэрэгжүүлсэн талаарх мэдээлэлгүй байна.
2. Хуулийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллагууд Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд бүрэн хамрагдаж, 3.1.4, 3.1.5-д заасан байгууллага хуулийн хэрэгжилтэд хамрагдаагүй байна.
3. Шилэн дансны мэдээллийг нэгдсэн систем болон байгууллагын мэдээллийн самбарт мэдээлэл байршуулах үүрэг бүхий зарим албан тушаалтнууд мэдээллээ бүрэн оруулаагүй байна.
4. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх журам, нэгдсэн цахим хуудсыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Тав. АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөмж болгож байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга С.Пүрэвжавт:

1. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн шилэн дансны хэрэгжилтэд хяналт тавих ажлын календарчилсан төлөвлөгөө гарган, биелэлтийг ханган ажиллах.

2. Сумын ИТХ-ын дарга нарт “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах талаар чиглэл өгч ажиллах

СТСХ-ийн дарга С.Хэрлэнчимэгт:

1. “Шилэн дансны тухай хууль”, “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг баримтлан шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг хуулийн хугацаанд нь бүрэн байршуулах талаар байгууллагын дарга, нягтлан бодогч, сумын санхүүгийн албаны дарга нарт боломжтой хэлбэрээр сургалт зохион байгуулах,

Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга Х.Гонгорт

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг тогтмолжуулж, гарсан алдаа, дутагдал, авсан арга хэмжээ, өгсөн зөвлөмжийн бүртгэлтэй болох, хуулийн хэрэгжилтийг сайжруулах.

ҮАГ-т тавих санал

Дараах саналыг ҮАГ-аас нэгтгэгдэн гарах тайланд тусгаж холбогдох байгууллагуудад хүргүүлэх зөвлөмжид оруулах. Үүнд:

1. Сумдын ЗДТГ-т төсөв нь багтаж байгаа 19 багийг шилэн дансны цэснээс байгууллагын нэрийг хасах.
2. Шилэн дансны мэдээлэлд хамрагдах ТЕЗ-ийн харьяа орон нутагт байгаа байгууллагыг тодорхой болго, мэдээний нэр төрлийн давхардлыг арилгах, дарааллыг цэгцтэй болгох, маягтуудыг хооронд нь уялдуулах, мэдээлэл нь иргэдэд ойлгоход энгийн, хялбар болгох,
3. Аж ахуйн нэгж, байгууллагуудын нэрийг Улсын бүртгэлийн албанаас оноосон нэртэй тулгалт хийж баталгаажуулах,
4. Үйл ажиллагаа явуулдаггүй, ажиллах эсэх нь тодорхойгүй төрийн өмчит ААН-дийг шилэн дансны тухай хуульд хэрхэн хамруулахыг шийдвэрлэх,
5. Шилэн дансны нэгдсэн цахим хуудас, хэрэгжүүлэх журмыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Зургаа. ХАВСРАЛТУУД

1. Хэнтий аймгийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн судалгаа /1-4 маягт/
2. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст нээсэн цэсний жагсаалт

Долоо. ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд аймгийн Аудитын газраас хийсэн нийцлийн аудитын тайлантай танилцлаа.

Хуулийн хэрэгжилтийг хангах, түүнд тавих хяналтыг тогтмолжуулахад цаашид холбогдох байгууллагууд дараах асуудалд анхаарах нь зүйтэй гэсэн саналтай байна.Үүнд:

1. Мэдээлэлд хамрагдах байгууллагыг Улсын бүртгэлийн програм дахь оноосон нэрээр нь байршуулах, нэрийн давхардлыг арилгах, орхигдсоныг нөхөж оруулах замаар төсвийн тухай хууль тогтоомж, эдийн засгийн салбарын ангилалтай нийцүүлж улсын хэмжээнд нэгдсэн дараалалд оруулах, мэдээлэл оруулсан огноог ил тод болгох;
2. Тухайн ТЕЗ-аас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд нь хяналт тавих байгууллага,нэгжийн нэрийг эрх бүхий байгууллагаас тогтоож батлагаажуулах;
3. Улсын бүртгэлд бүртгэгдсэн боловч үйл ажиллагаа явуулаагүй, улс, орон нутгийн төсвөөс санхүүжилт аваагүй байгууллагын мэдээллийг хэрхэн байршуулахыг журамд тодорхой тусгаж өгөх;
4. Нэгдсэн цахим хуудсанд зарим мэдээллийг байршуулах цэсгүйгээс уг мэдээлэл бүрэн шивэгдэхгүй байгаа тул мэдээллийн холбогдох үзүүлэлтийг цэгцтэй, тодорхой, иргэд ойлгоход хялбар болгох талаар хууль журамд өөрчлөлт оруулах, мэдээллийг холбогдох програм хангамжаас шууд хөрвүүлэн байршуулах нөхцөлийг бүрдүүлэх;
5. Төсвийн байгууллагын нэмэлт дансны гүйлгээг нэгдсэн цэсэнд оруулж байршуулах;
6. Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан журамд " Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд тухайн байгууллагын дотоод хяналтын нэгж, ажилтан байнгын хяналт тавьж байх" – аар нэмэлт өөрчлөлт оруулах;
7. Тухайн байгууллага, албан тушаалтны ажил, үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэхэд Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-д заасны дагуу хуулийн хэрэгжилтийн үзүүлэлтийг харгалзан үздэг болгох нь зүйтэй гэж үзэж байна.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН
АЛБАНЫ ДАРГА Х.ГОНГОР

Дээрхи ирүүлсэн саналаас холбогдох байгууллагууд цаашид анхаарах асуудлууд нь тайланд орсон учраас тайланд нэмэлт засвар хийгээгүй болно.

Тайлан бичсэн: Ахлах аудитор

Н.Туяа

Шинжээч

Д.Эрдэнэбилэг

Шинжээч

Б.Мөнгөнцэцэг

